



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Айраг сумын эрүүл мэндийн төвийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/84/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд судамж,
3 дугаар баг, Сайншата сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.03.24 № 1-6/242

таниг _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзлээ.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын сангаас төлөх зардлын төлбөрийг тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр тооцож, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох болсон байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,149.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 481.5 сая төгрөгийн 18 гүйлгээ, 34.5 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 307.3 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш

үнийн дүн бүхий 30.3 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 169.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 21 харилцагчдаас 15.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тооллогыг 12 сарын 15-наас 23-ны хооронд хийсэн ч 12 сарын 31-нээрх эцсийн үлдэгдэл болгон санхүүгийн тайланд тусгасан. Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 45 нэр төрлийн анхны дансны үнэтэй, 61.5 сая төгрөгийн 58 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүд ашиглагдаж байна. Энэ нь УСНББОУС 17, Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь

санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана", 49 дүгээр зүйлд тусгасан "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалттай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 6 зорилт, 23 арга хэмжээний хэрэгжилт 90.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 76.5 хувийн биелэлттэй байна.

Дорноговь аймгийн Айраг сумын Эрүүл мэндийн төв нь төсвийг хэмнэлттэй зарцуулж хүрэх үр дүндээ хүрч ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	262,194,912.39	347,074,781.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,571,308.85	108,904,412.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,571,308.85	108,904,412.26
3121	Төгрөг	1,571,308.85	108,904,412.26
31211	Төрийн сангийн харилцах	-	108,904,412.26
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,571,308.85	-
33	АВЛАГА	140,284,700.00	17,358,030.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	730,834.00
335	Бусад авлага	140,284,700.00	16,627,196.00
3351	Байгууллагаас авах авлага	140,284,700.00	16,627,196.00
35	БАРАА МАТЕРИАЛ	120,338,903.54	220,812,339.29
351	Түүхий эд материал	73,781,813.64	147,379,181.89
35110	Тусгай зориулалттай материал	44,336,883.16	78,467,442.26
35130	Эм боох материал	29,444,930.48	68,911,739.63
354	Хангамжийн материал	46,557,089.90	73,433,157.40
35410	Бичиг хэргийн материал	1,671,740.00	3,985,640.00
35420	Аж ахуйн материал	2,490,200.00	2,345,085.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,971,475.00	12,197,975.00
35440	Түлш, шатах тослох материал	2,155,700.00	1,457,450.00
35460	Хүнсний материал	2,176,784.00	3,789,388.50
35470	Бусад хангамжийн материал	33,091,190.90	49,657,618.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	731,430,285.02	776,307,018.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	731,430,285.02	776,307,018.98
392	Биет хөрөнгө	722,842,972.42	768,151,456.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	543,671,052.00	543,671,052.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,851,989.96)	(50,501,701.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,194,000.00	94,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,894,000.00)	(14,850,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,016,601.49	256,917,273.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,360,887.04)	(106,517,821.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,461,033.00	30,281,033.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,483,645.38)	(16,146,745.34)
39209	Зам, гүүрийн байгууламж	30,814,529.00	30,814,529.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,198,723.92)	(5,598,298.56)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,500,000.00	2,500,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(1,083,333.42)	(1,583,333.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,645,196.00	7,645,196.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,703,424.35)	(3,796,291.95)
39217	Ном	1,116,565.00	1,116,565.00
393	Биет бус хөрөнгө	8,587,312.60	8,155,562.68
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(539,687.40)	(971,437.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,400,000.00	7,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	993,625,197.41	1,123,381,800.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,452,259.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,452,259.00	-
413	Өглөг	36,452,259.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,452,259.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	957,172,938.41	1,123,381,800.53
51	Засгийн газрын хувь оролцоо	957,172,938.41	1,123,381,800.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	362,199,694.83	362,199,694.83
51101	Өмч: - төрийн	362,199,694.83	362,199,694.83
512	Хуримтлагдсан үр дүн	525,531,496.39	726,200,262.70
51210	Өмнөх үеийн үр дүн	525,531,496.39	559,991,400.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	166,208,862.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,441,747.19	34,981,843.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	993,625,197.41	1,123,381,800.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	524,420,919.00	831,397,819.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	117,773,155.78
120	Нийтлэг татварын бус орлого	-	117,773,155.78
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө		51,083,293.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал		66,689,862.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,420,919.00	713,624,663.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,103,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,103,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,525,970.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,525,970.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,190,119.00	49,857,583.64
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,190,119.00	49,857,583.64
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,600,930.00	663,767,080.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,600,930.00	663,767,080.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	976,625,997.21	663,902,165.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	976,625,997.21	663,902,165.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,825,997.21	663,902,165.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,527,152.00	332,737,488.76
210101	Үндсэн цалин	194,200,000.00	204,586,045.21
210102	Нэмэгдэл	140,122,971.00	95,121,524.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,016,000.00	8,425,000.00
210104	Урамшуулал	19,188,181.00	24,604,919.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,158,913.46	47,819,915.93
210201	Тэтгэврийн даатгал	31,150,513.46	35,697,594.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,752,100.00	2,833,738.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,201,700.00	2,479,629.77
210204	Ажилгүйдлийн даатгал	550,400.00	609,978.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,504,200.00	6,198,974.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,318,189.00	39,743,123.64
210301	Гэрэл, цахилгаан	3,278,383.00	2,907,201.64
210302	Түлш, халаалт	29,822,100.00	29,821,200.00
210303	Цэвэр, бохир ус	9,217,706.00	7,014,722.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,766,565.28	34,092,295.20
210401	Бичиг хэрэг	3,083,303.28	2,928,600.00
210402	Тээвэр, шатахуун	21,534,200.00	21,301,975.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,439,647.00	1,984,753.20
210404	Ном, хэвлэл	51,200.00	6,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,595,303.00	1,172,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,763,412.00	6,697,927.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	289,500.00	-
210408	Бараа материал акталсны зардал	10,000.00	-
2105	Нормативт зардал	414,970,731.34	146,786,318.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400,190,510.34	133,951,986.92
210502	Хоол, хүнс	10,781,021.00	9,769,456.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,999,200.00	3,064,875.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,294,748.00	12,584,860.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	51,888.00	300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,533,000.00	-
210604	Урсгал засвар	2,709,860.00	12,584,560.00
2107	Томилолт, зочны зардал	700,600.00	2,011,000.00
210702	Дотоод албан томилолт	700,600.00	2,011,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,209,639.00	2,283,096.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,411,661.00	1,503,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	253,200.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,378.00	169,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,000.00	84,178.00
210807	Газрын төлбөр	7,400.00	7,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,879,459.13	45,844,067.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	288,200.00	1,973,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,591,259.13	43,870,467.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,800,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,800,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,800,000.00	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(452,205,078.21)	167,495,653.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	236,979.27	1,286,791.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	236,979.27	1,286,791.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(236,979.27)	(1,286,791.52)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(452,442,057.48)	166,208,862.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	524,420,919.00	840,490,523.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	524,420,919.00	840,490,523.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,103,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,103,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,525,970.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,525,970.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,190,119.00	49,857,583.64
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,190,119.00	49,857,583.64
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,600,930.00	790,632,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,600,930.00	790,632,940.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	614,198,910.15	694,206,720.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	614,198,910.15	694,206,720.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,398,910.15	694,206,720.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,074,893.00	373,128,937.47
210101	Үндсэн цалин	194,200,000.00	208,455,443.71
210102	Нэмэгдэл	103,670,712.00	131,643,574.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,016,000.00	8,425,000.00
210104	Урамшуулал	19,188,181.00	24,604,919.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,158,913.46	47,819,916.22
210201	Тэтгэврийн даатгал	31,150,513.46	35,697,594.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,752,100.00	2,833,738.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,201,700.00	2,479,629.77
210204	Ажилгүйдлийн даатгал	550,400.00	609,978.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,504,200.00	6,198,974.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,318,189.00	39,743,123.64
210301	Гэрэл, цахилгаан	3,278,383.00	2,907,201.64
210302	Түлш, халаалт	29,822,100.00	29,821,200.00
210303	Цэвэр, бохир ус	9,217,706.00	7,014,722.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,436,207.00	40,780,878.20
210401	Бичиг хэрэг	2,561,900.00	4,773,600.00
210402	Тээвэр, шатахуун	20,634,660.00	20,569,525.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,239,647.00	1,934,753.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,733,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	10,770,000.00
2105	Нормативт зардал	107,773,438.69	145,661,288.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,773,438.69	127,539,573.70
210502	Хоол, хүнс	10,000,000.00	11,203,615.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	6,918,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,927,230.00	37,444,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,521,000.00	6,116,660.00
210602	Тавилга	180,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,405,000.00	11,700,000.00
210604	Урсгал засвар	2,821,230.00	19,627,660.00
2107	Томилолт, зочны зардал	700,600.00	2,011,000.00
210702	Дотоод албан томилолт	700,600.00	2,011,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,209,639.00	2,283,096.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,411,661.00	1,503,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	253,200.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,378.00	169,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,000.00	84,178.00
210807	Газрын төлбөр	7,400.00	7,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,799,800.00	5,334,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,799,800.00	5,334,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,800,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,800,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,800,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(89,777,991.15)	146,283,803.41
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,023,500.00	38,950,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,023,500.00	38,950,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,023,500.00	38,950,700.00
222001	Тоног төхөөрөмж	8,479,000.00	38,950,700.00
223001	Бусад хөрөнгө	3,265,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,279,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(18,023,500.00)	(38,950,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(107,801,491.15)	107,333,103.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,571,308.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,571,308.85	108,904,412.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	362,199,694.83	69,441,747.19	295,525,491.25	727,166,933.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	362,199,694.83	69,441,747.19	295,525,491.25	727,166,933.27
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	230,006,005.14	230,006,005.14
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	362,199,694.83	69,441,747.19	525,531,496.39	957,172,938.41
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	362,199,694.83	69,441,747.19	525,531,496.39	957,172,938.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,459,904.19	34,459,904.19
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	362,199,694.83	69,441,747.19	559,991,400.58	991,632,842.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(34,459,904.19)	-	(34,459,904.19)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	166,208,862.12	166,208,862.12
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	362,199,694.83	34,981,843.00	726,200,262.70	1,123,381,800.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	904,568,200.00	692,148,632.23	212,419,567.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	904,568,200.00	692,148,632.23	212,419,567.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	904,568,200.00	692,148,632.23	212,419,567.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,832,700.00	336,676,678.47	36,156,021.53
210101	Үндсэн цалин	213,890,400.00	208,455,443.71	5,434,956.29
210102	Нэмэгдэл	121,141,100.00	95,191,315.76	25,949,784.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,401,200.00	8,425,000.00	2,976,200.00
210104	Урамшуулал	26,400,000.00	24,604,919.00	1,795,081.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,983,600.00	43,263,387.22	5,720,212.78
210201	Тэтгэврийн даатгал	35,625,100.00	31,141,065.38	4,484,034.62
210202	Тэтгэмжийн даатгал	3,433,400.00	2,833,738.72	599,661.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,646,800.00	2,479,629.77	167,170.23
210204	Ажилгүйдлийн даатгал	661,600.00	609,978.81	51,621.19
210205	Эрүүл мэндийн даатгал	6,616,700.00	6,198,974.54	417,725.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,103,100.00	39,743,123.64	3,359,976.36
210301	Гэрэл, цахилгаан	3,377,300.00	2,907,201.64	470,098.36
210302	Түлш, халаалт	29,822,100.00	29,821,200.00	900.00
210303	Цэвэр, бохир ус	9,903,700.00	7,014,722.00	2,888,978.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,854,500.00	40,780,878.20	37,073,621.80
210401	Бичиг хэрэг	7,350,000.00	4,773,600.00	2,576,400.00
210402	Тээвэр, шатахуун	48,187,000.00	20,569,525.00	27,617,475.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,817,500.00	1,934,753.20	882,746.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,250,000.00	2,733,000.00	2,517,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,250,000.00	10,770,000.00	3,480,000.00
2105	Нормативт зардал	237,134,500.00	145,661,288.70	91,473,211.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	203,967,700.00	127,539,573.70	76,428,126.30
210502	Хоол, хүнс	23,166,800.00	11,203,615.00	11,963,185.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	6,918,100.00	3,081,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,723,000.00	74,086,120.00	26,636,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,003,700.00	42,758,460.00	6,245,240.00
210602	Тавилга	1,000,000.00	-	1,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,340,000.00	11,700,000.00	10,640,000.00
210604	Урсгал засвар	28,379,300.00	19,627,660.00	8,751,640.00
2107	Томилот, зочны зардал	2,651,600.00	2,011,000.00	640,600.00
210702	Дотоод албан томилот	2,651,600.00	2,011,000.00	640,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,105,200.00	2,283,096.00	2,822,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,964,400.00	1,503,050.00	2,461,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	350,400.00	159,000.00	191,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,400.00	169,468.00	140,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	84,178.00	15,822.00
210807	Газрын төлбөр	20,000.00	7,400.00	12,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,180,000.00	7,643,060.00	8,536,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,180,000.00	7,643,060.00	8,536,940.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	904,568,200.00	799,481,735.64	105,086,464.36
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,103,100.00	49,857,583.64	8,245,516.36
132001	Орон нутгийн төсвөөс	58,103,100.00	49,857,583.64	8,245,516.36
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	729,177,900.00	650,348,240.00	78,829,660.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	729,177,900.00	650,348,240.00	78,829,660.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	117,287,200.00	99,275,912.00	18,011,288.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	117,287,200.00	-	117,287,200.00
1200047	Нэмэлтийн үлдэгдлээс ирсэн мөнгөн хөрөнгө		99,275,912.00	(99,275,912.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний		1,571,308.85	(1,571,308.85)

	үлдэгдэл			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		108,904,412.26	(108,904,412.26)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	141,856,008.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	141,856,008.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	41,008,788.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	36,452,259.00
210102	Нэмэгдэл	-	36,452,259.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,556,529.00
210201	Тэтгэврийн даатгал	-	4,556,529.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	100,847,220.85
213305	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	100,847,220.85
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	140,284,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	140,284,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		140,284,700.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,571,308.85
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,571,308.85	1.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 303.9 сая төгрөгийн 7 алдаа¹ илэрснээс аудитын явцад 303.9 сая төгрөгийн 7 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдэл 34.5 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулсан.
2. Цалингийн зардалд бараа материалын 0.7 сая төгрөгийг алдаатай бүртгэснийг залруулсан.
3. Нэмэлтийн данснаас шилжүүлсэн 99.3 сая төгрөгийг орлого, зардлаар бүртгэснийг залруулсан.
4. Мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд өмнөх оны 140.3 сая төгрөгийн авлага төлөгдсөнийг бүртгээгүй байсныг залруулсан.
5. 8.9 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцсон, хасагдсан хөрөнгийн 0.5 сая төгрөгийн элэгдлийг дутуу хассаныг залруулсан.
6. Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө хооронд шилжсэн ахмадын сангийн 3.2 сая төгрөгийг цалингийн зардалд бүртгэсэн.
7. Эрүүл мэндийн даатгалаас авах нэг иргэний нормативт санхүүжилтийн 11, 12-р сарын 20% болох 16.6 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсныг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 5 зөрчил² илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,149.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 481.5 сая төгрөгийн 18 гүйлгээ, 34.5 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 307.3 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.3 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 169.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 21 харилцагчдаас 15.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 15-наас 23-ны хооронд зохион байгуулсан ч 12 дугаар сарын 31-нээрх эцсийн үлдэгдлээр санхүүгийн тайланд тусгасан. Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнг тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад зөрүүтэй байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэх байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж /хэзээ, ямар дансыг, аль өдрийн үлдэгдлээр тоолсон эсэх/, акт үйлдэж байх.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 45 нэр төрлийн анхны дансны үнэтэй, 61.5 сая төгрөгийн 58 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг ашиглагдаж байна.

УСНББОУС 17, Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана”, 49 дүгээр зүйлд тусгасан “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” заалттай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 49, 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх асуудлыг шийдвэрлэх.

Дээрх албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлгээний нэмэгдэл 34.5 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн	1	34,459.9	0	-	1	34,459.9	1	34,459.9	0	-		
Цалингийн зардалд бараа материалын 0.7 сая төгрөгийг алдаатай бүртгэсэн	1	661.0	0	-	1	661.0	1	661.0	0	-		
Нэмэлтийн данснаас шилжүүлсэн 99.3 сая төгрөгийг орлого, зардлаар бүртгэсэн	1	99,275.9	0	-	1	99,275.9	1	99,275.9	0	-		
Мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд өмнөх оны 140.3 сая төгрөгийн авлага орсонг бүртгээгүй	1	140,284.7	0	-	1	140,284.7	1	140,284.7	0	-		
8.9 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцсон, хасагдсан хөрөнгийн 0.5 сая төгрөгийн элэгдлийг дутуу хассан	1	9,432.4	0	-	1	9,432.4	1	9,432.4	0	-		
Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө хооронд шилжсэн ахмадын сангийн 3.2 сая төгрөгийг цалингийн зардалд бүртгэсэн	1	3,208.4	0	-	1	3,208.4	1	3,208.4	0	-		
Эрүүл мэндийн даатгалаас авах нэг иргэний нормативт санхүүжилтийн 11, 12-р сарын 20% болох 16.6 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй	1	16,627.2	1	16,627.2								
Дүн	6	303,949.5	1	16,627.2	6	287,322.3	6	287,322.3	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын тулгалтаар 21 харилцагчдаас 15.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1						
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна.	1						1						
Жилийн эцсийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 15-наас 23-ны хооронд зохион байгуулсан ч 12 дугаар сарын 31-нээрх эцсийн үлдэгдлээр санхүүгийн тайланд тусгасан. Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнг тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад зөрүүтэй байна.	1						1						
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 45 нэр төрлийн анхны дансны үнэтэй, 61.5 сая төгрөгийн 58 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг ашиглагдаж байна.	1						1						
Дүн	4						4						-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,149.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 481.5 сая төгрөгийн 18 гүйлгээ, 34.5 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 307.3 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.3 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 169.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-		-		1		-	
Дүн	1		-		-		1		-	